



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИНВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/18

Шинэговь сум

Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр  
сонгон шалгаруулах үнэлгээний хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаал "Хүнсний эрхийн бичиг олгох журам"-ын 6.6-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Суманд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр сонгон шалгаруулах үнэлгээний хороог зөвшилцсөнөөр дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Ж.Батмөнх (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	З.Баасандалай (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүн:	Б.Базаррагчаа (аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сум хариуцсан мэргэжилтэн)
Хөндлөнгийн төлөөлөл:	А.Нандинцэцэг (1 дүгээр багийн иргэн) Ш.Буяннэмэх (2 дугаар багийн иргэн)

2. Суманд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zakiramj.doc

Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах /Шивээговь/ ажлын бараа нийлүүлэх үнийн санал авах тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны дүгнэлт

2020.02.12

Шивээговь сум

Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/32 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ыг үндэслэн “Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах /Шивээговь/ ажил” ГСАХХҮГ/202001002-ын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу цахим хэлбэрээр зарлаж, 27, 28-р зүйл болон Сангийн сайдын 2012 оны 09 -р сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Цахим тендер шалгаруулалтад “Оюу шивээ арвижих” ХХК, “Шивээгийн хөгжил” ХХК тендерт үнийн саналаа ирүүлсэн ба үнэлгээний хорооны гишүүдийн 100%-ийн саналаар “Оюу шивээ арвижих” ХХК-ийг сонгон шалгаруулахаар болов.

“Шивээгийн хөгжил” ХХК-ийн шалгараагүй үндэслэл:

1. Хүнсний дэлгүүрийн агуулах зоорь нь шаардлага хангаагүй. / Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт/

2. Ирүүлсэн үнийн санал нь Сангийн сайдын 2012 оны 09 -р сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”-ын 7.6 дахь заалтад “Тендерт оролцогчоос тодорхойгүй шаардлага, нөхцөл (түхэйлбал “урьдчилгаа төлбөрийн хэмжээг ихэсгэхийг хүсч байна” эсвэл “дүүсгах хуваарийг өөрчлөх талаар хэлэлцэхийг хүсч байна”)-ийг ТББ-т зааснаас зөрүүтэйгээр илэрхийлбэл тэдгээрийг ердийн нөхцөлд тендерийн үнэлгээнд авч үзэхгүй. Гэвч тендерт оролцогч ТББ-т заасан шаардлагаас эрс өөрөөр хөдлөшгүй санал ирүүлэх нь түүний тендерээс татгалзах үндэслэл болно гэж заасныг үндэслэл болгож Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах /Шивээговь/ ажил” ГСАХХҮГ/202001002-ын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичигт заасан шаардлагаас эрс өөрөөр хөдлөшгүй үнийн санал ирүүлсэн гэж үзсэн болно.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО